



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/21

Бат-Өлзий сум

Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг  
малаас чөлөөлөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.1.13 дахь заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, "Төлөвлөгөө батлах тухай" сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 20/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрийн намар, өвлийн бэлчээр, хадлангийн талбайг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд чөлөөлсүгэй.

2.Чөлөөлөгдөх нутаг дэвсгэрийн нэгжийг хавсралтаар баталсугай.

3.Заасан хугацаанд малчин, мал бүхий иргэдэд зар мэдээллийг шуурхай хүргэж, нутаг дэвсгэрийг чөлөөлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2024 оны  
06 дугаар сарын 03-ны өдрийн А/121  
дүгээр захирамжийн хавсралт

## ЧӨЛӨӨЛӨГДӨХ НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭРС

1 дүгээр баг Бургасыг чөлөөлж Татуур, Хөрөө хүрэм, Улаанцутгалан, Мухдагын ам, Хүйс толгой, Хөнөгийг чөлөөлж Хөнөгийн ам, Хөнөгийн голоор, Мухдагыг чөлөөлж Мухдагын ам, Улаан цутгалан, Улааныг чөлөөлж Улаан-Ам, Улаан-Амны төв, Богчны хөндийд буух

2 дугаар баг Хамрын эхийг чөлөөлж Хамрын гол, Цагаан гол, Бугатыг чөлөөлж Бугатын ам, Баруунсөдтийг чөлөөлж Хөнөгийн гол, Цагаан тохой хөвөө,

3 дугаар баг Могойтыг чөлөөлж Могойтын ам, Цагаан гол, Мойлтыг чөлөөлж Мойлтын ам, Цагаан голд буух

4 дүгээр баг Галтыг чөлөөлж Намгын гол, Хустын рашаан, Бага цутгалан, Бөхөн шарыг чөлөөлж Бөхөн шарын ам, Намгын гол, багийн төв, Урд-Агуйтыг чөлөөлж Урд - Агуйтын ам, Намгын гол, Нарийн хужиртыг чөлөөлж Баруун Хужирт, Хойд-Агуйтыг чөлөөлж Санж, Хөндлөн булаг, Нам талруу, Онгоцтыг чөлөөлж Орхоны хөвөө, Цагаан голруу буух.

5 дугаар баг Өвтийг чөлөөлж Өвтийн амруу буух.

6 дугаар баг Уурагыг чөлөөлж Цагаан нуур, Шавартыг чөлөөлж Цагаан нуур, Улаан амны хойд ширгүү, Хятрууныг чөлөөлж Хятрууны ам, Битүүтийг чөлөөлж Бөөргийн Хөндийрүү Улиастайн дэнж, Хурц, Шивэртийг чөлөөлж Баруун гол, Тамчийн тал, Горхиндэнжийг чөлөөлж Уугийн голд тус тус буух.

---oOo---